



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2006 9 7
ОНЫ САРЫН өдөр

Дугаар 312

Улаанбаатар

Гадаадад суралцуулах тухай

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2005 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 52 дугаар тушаалаар батлагдсан “Өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах журам”, Өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт Сургалтын төрийн сангийн зээлээр өөрийн захиалгаар хүн суралцуулах эрх бүхий байгууллагын саналыг үндэслэн ТУШААХ нь:

1. Баярмагнай овогтой Мөнх-Амарыг Япон Улсын Нагаокагийн их сургуулийн /Nagaoka university/ магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаагаар 2006-2007 оны хичээлийн жилээс суралцуулсугай.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Санхүү, эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан “Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам”-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /Р.Бат-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.



САЙД

С. Ганзор - сб

Ө.ЭНХТҮҮВШИН

03 2220